



12

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 04 өдөр


Дугаар 5/09

Улаанбаатар хот

Шагнаж урамшуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 292 дугаар тушаал, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн дагуу хугацаанд нь үнэн зөв гаргаж, аудитын зөрчилгүй дүгнэлт авсан Ахлах нягтлан бодогч Г.Ганцэцэг, Нярав Э.Ундармаа нарыг нэг сарын цалингаар шагнаж урамшуулсугай.
2. Урамшууллыг цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас бодож олгохыг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  С.БАТЖАРГАЛ



53

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 8/12

Улаанбаатар хот

Нэг удаагийн буцалтгүй тусламж
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.5 дахь заалт, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8, Хөдөлмөрийн дотоод журмын 8.3.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гэр бүлд нь шинээр хүн мэндэлсэн баярт үйл явдлыг тохиолдуулан байгууллагын мэргэжилтнүүдэд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2.Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох мэргэжилтнүүдийг нэрсийг хавсралтаар баталсугай.


3.Тусламж үзүүлэхэд шаардагдах 500,000 (Таван зуун мянга) төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.БАТЖАРГАЛ

54
Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,
технологийн парк" ОНӨААТҮГазрын даргын
2022 оны 11 сарын 14 -ны өдрийн 2/14 тоот
тушаалын хавсралт



НЭГ УДААГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС

№	Овог нэр	Олгох тэтгэмж
1	Хангай Бямбаа	125000
2	Ганбаатар Ганцэцэг	125000
3	Отгонбаяр Чулуун -Эрдэнэ	125000
4	Бямбадорж Болортуяа	125000
	Нийт дүн	500000